



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 1/533

Чойбалсан

Г

Комисс томилох тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн 2025 оны төсөв батлах тухай" 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит 3 дугаар хуралдааны 03/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх "Шинэ усан сан-10 төслийн хүрээнд төвлөрсөн болон ухаалаг худаг нэмэгдүүлэх, цэвэршүүлэгч төхөөрөмж нэмэгдүүлэхэд шаардлагатай бараа материал худалдан авах" ажлыг батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Э.Саранхүү

-Матад сумын Засаг дарга

Нарийн бичиг:

Г.Өнөрцэцэг

-Матад сумын Засаг даргын тамгын газрын
Мэдээллийн ажилтан

Гишүүд:

М.Гансүмбэр

-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан ахлах
мэргэжилтэн

М.Эрдэнэбат

-Дорнод нийтийн аж ахуй ОНӨААТҮГ-ын
цахилгааны инженер

Б.Өлзийсуурь

-Гүйцэтгэгч компанийн төлөөлөл
"Баялаг говь" ХХК-ийн ажилтан

2.Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх "Шинэ усан сан-10 төслийн хүрээнд төвлөрсөн болон ухаалаг худаг нэмэгдүүлэх, цэвэршүүлэгч төхөөрөмж нэмэгдүүлэхэд шаардлагатай бараа материал худалдан авах" ажлыг батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулж, дүгнэлтийг баталгаажуулахыг комиссын дарга (Э.Саранхүү)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

ЗАСАГ ДАРГЫН

Э.САРАНХҮҮ

My computer D/ Zakhramj
2123011388

